




УЛААНБААТАР ХОТ  
БАТЛАВ  
“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ”  
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Ш.БАЯНМӨНХ



УЛААНБААТАР ХОТ  
БАТЛАВ  
“ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨГЖЛИЙН ТӨВ”  
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ  
Я.НЯМЖАРГАЛ

### ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2022 оны 04 сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

№ АХТ/СҮБ-28/2022  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ 40/2022

Иргэний хуулийн 476-482 дугаар зүйл, Эрчим хүчний сайдын 2019 оны 85 дугаар тушаал, Эрчим хүчний зохицуулах хорооны 2022 оны 1/200 тоотор өгсөн үүргийг хэрэгжүүлэх зорилгоор нэг талаас “Амгалан дулааны станц” ТӨХК (цаашид “Захиалагч” гэх)-ийн Гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх, нөгөө талаас “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ (цаашид “Сургалтын байгууллага” гэх)-ыг төлөөлж Э.Энхтайван нар нь Эрчим хүчний Сургалт үйлдвэрлэлийн цогцолборт 2022 онд зохион байгуулагдах сургалтуудад Амгалан дулааны станц ТӨХК-ийн ажилтнуудыг сургахтай холбогдсон харилцааг зохицуулахаар энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү гэрээгээр сургалтын хуваарь, төлбөр, сургалтад хамрагдах ажилтны тоо зэрэгтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Сургалтын байгууллагад төвлөрүүлбэл зохих хөрөнгийн хэмжээнд тохируулж Захиалагч байгууллагатай харилцан зөвшилцсөн сургалтын хөтөлбөр батлах бөгөөд уг хөтөлбөр нь энэхүү гэрээний нэгдүгээр хавсралтаар баталгаажина.
- 1.3. Энэхүү гэрээ нь 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- 1.4. Энэхүү гэрээтэй холбоотой аливаа асуудлыг Захиалагч талаас: Сургалт, судалгааны мэргэжилтэн Н.Пагмаа / Утас: 98071123 /,

Хоёр. Захиалагч талын эрх, үүрэг

- 2.1. Захиалагч тал нь сургалтын байгууллагын боловсруулсан сургалтын хөтөлбөртэй танилцах, сургалтын хуваарийн дагуу ажилтнуудаа сургалтад хамруулна.
- 2.2. Батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалт явуулахыг шаардах, цагийн хуваарийн дагуу явуулж байгаа эсэхэд хяналт тавина.
- 2.3. Сургалтад хамрагдах ажилтны мэдээллийг сургалтын байгууллагад урьдчилан гаргаж өгнө.
- 2.4. Үйлдвэртэй танилцах дадлага хийх нөхцөл боломжоор хангаж, хяналт тавьж ажиллана.
- 2.5. Захиалагч талаас сургалтын чанар, сургалтын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гомдол саналыг гаргана.
- 2.6. Суралцагчийн мэдээлэл өөрчлөгдөхөд сургалтын төвд урьдчилан мэдэгдэнэ.

2.7. Сургалтын хөтөлбөрийг зөвхөн сургалтын үйл ажиллагаанд ашиглах бөгөөд бусдад дамжуулахгүй байх үүрэгтэй.

2.8. Давтан шалгалт өгөх, ажилтнаас хамаарч сургалтанд хамрагдаагүй хугацааны зардалыг /гэрээний 3.7-д хамаарах зардал/ хариуцахгүй.

#### Гурав. Сургалтын байгууллагын эрх, үүрэг

3.1. Батлагдсан хөтөлбөр, цагийн хуваарийг нарийн баримталж сургалт зохион байгуулна.

3.2. Сургалтын материал, гарын авлага, тараах материалаар суралцагчдыг хангана.

3.3. Ажилтан сургалтанд хамрагдах хугацаанд суралцагчдын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хариуцна.

3.4. Сургалтын байгууллага нь сургалтанд бүрэн хамрагдсан, шалгалтанд амжилттай дүн үзүүлсэн суралцагчдад мэргэшлийн үнэмлэх, сертификат олгоно.

3.5. Суралцагчдын сургалтын үнэлгээ, ирцийн мэдээллийг захиалагч талд тухай бүр нь хүргүүлнэ.

3.6. Сургалтын хуваарьт өөрчлөлт орвол урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.

3.7. Сургалтын байгууллагын зохион байгуулсан сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцээгүй шалтгаанаар давтан сургалтад хамрагдах тохиолдолд түүний сургалтын төлбөрийг 50% хөнгөлнө.

#### Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

4.1. Сургалтын хуваарь болон хамрагдах хүний тоо өөрчлөгдөх тохиолдолд талууд урьдчилан албан бичиг, цахимаар хүсэлт илгээн харилцан тохиролцож, Хавсралт №1-д заагдсан сургалтын хуваарьт өөрчлөлт оруулж болно.

4.2. Гэрээнд заагдсан асуудлаар талуудын хооронд маргаан үүсвэл, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэх ба зөвшилцөлд эс хүрвэл Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

4.3. 2022 оны 12 сард гэрээний биелэлтийг талууд хамтран дүгнэх ба төвлөрүүлсэн үнийн дүнд багтаан тухайн ондоо ажилтнуудыг сургалтуудад хамруулах ажлыг зохион байгуулна.

#### Тав. Төлбөрийн нөхцөл

5.1. Төлөвлөгөөт сургалтын нийт зардал 12,000,000 / Арван хоёр сая төгрөг/-н төлбөрийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан төвлөрүүлнэ.

5.2. Төлбөрийг Эрчим хүчний хөгжлийн төвийн Голомт банкны 2105010095 тоот дансанд төвлөрүүлнэ.

#### Зургаа. Бусад зүйл

6.1. Гэрээгээр зохицуулаагүй аливаа харилцааг Монгол Улсын хуулийн дагуу зохицуулна.


6.2. Энэхүү гэрээг талууд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

6.3. Гэрээг хоёр хувь үйлдэх бөгөөд талууд тус бүр 1 хувийг авна.

6.4. Талууд гэрээг цуцлах буюу түр зогсоохыг хүсвэл нөгөө талдаа 14-өөс доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:


Захиалагчийг төлөөлж:

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ  
НЯГТЛАН БОДОГЧИЙН АЖИЛ  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
 Ө.УДВАЛ

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

 Б.ГАН-ОЧИР

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН  
Г.САРУУЛ



СУРГАЛТ, СУДАЛГААНЫ  
МЭРГЭЖИЛТЭН

 Н.ПАГМАА

Хаяг :БЗД 8-р хороо УС-15-1-1  
Утас: 77111152

Гүйцэтгэгчийг төлөөлж:

СУДАЛГАА, ХӨГЖИЛ, СУРГАЛТ  
ХАРИУЦСАН ДЭД ЗАХИРАЛ

 Д.БАССАЙХАН


ХҮНИЙ НӨӨЦ, ГЭРЭЭ, ЭРХ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

 П.САНЛИГРЭНЧИН

САНХҮҮ, АЖ АХУЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ НЯГТЛАН  
БОДОГЧ

 Д.ЭРДЭНЭЧИМЭГ

СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН  
ЦОГЦОЛБОРЫН ЭРХЛЭГЧ

 Э.ЭНХТАЙВАН

Хаяг : УБ хот ХУД 3-р хороо Засгийн газрын  
4-р байрны өргөтгөл  
Утас: 77116030